

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-10
<hr/>	
<i>1..Шинэжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	5-8
<i>2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	8-10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
05 дугаар сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 05 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Г.Дамдинням, Г.Мөнхцэцэг;

Чөлөөтэй: Б.Баярсайхан, Ё.Баатарбилэг.

Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох, ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректор М.Намнан, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэний дагуу санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.10-д заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 9 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын дэд сайд П.Баттөр, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Г.Батхуяг, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн Ц.Чулуунбат, Ая зохиогч, продюсер, Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн гишүүн Д.Өлзий-Орших, Монголын анимейшний холбооны гүйцэтгэх захирал Э.Тамир, “М мюзик” ХХК-ийн захирал Д.Батмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундррам танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд ишлжүүлсэний дагуу санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: 1.А.Адъяасүрэн, П.Анужин, Т.Аубакир, Э.Батшугар, Г.Дамдинням, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, /цаашид тохиолдол бүрт нийцүүлэн өөрчлөх/, 12.4 дэх хэсгийн “нөхцөл,” гэсний дараа “системийн мэдээллийг бүрдүүлэх этгээдэд тавих шалгуур,” гэж нэмж, 12.9 дэх хэсгийн “төрөөс” гэснийг болон 12.10 дахь хэсгийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай “12.8” дахь хэсэг нэмэх:

“12.8.Энэ хуулийн 12.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн 17.2-т заасан объектын төрөл тус бүрийн зохиогчийн эрх эзэмшигчийн олонхийг нэгтгэсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.3-12.6” гэснийг “12.3, 12.5, 12.7” гэж, “12.9 дэх хэсгийн “бүтээгдэхүүний зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн чиглэлээр” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага нь” гэж өөрчилж, 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.6, 12.7 дахь хэсэг болгох:

“12.6.Энэ хуулийн 12.3-т заасан систем хөгжүүлэлтийг гүйцэтгэх этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулна.

12.7.Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах системийн мэдээллийг бүрдүүлэх, хэрэглэх чиг үүргийг хамтын удирдлагын байгууллага, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан үндсэн чиглэл тус бүрийн мэргэжлийн нэгдсэн холбоо гүйцэтгэж болно. Холбогдох этгээдийг энэ хуулийн 12.4-т заасан шалгуурын дагуу сонгох, санхүүжүүлэх, хяналт тавих чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 25 минут үргэлжилж, 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.7 хувийн ирцтэйгээр 09 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 09 цаг 05 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Мөнхцэцэг: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу ирцийг танилцуулъя.

Ирвэл зохих 16 гишүүнээс ирсэн 9 гишүүн байна. Телуханы Аубакир гишүүн 2 дугаар тойрог, Энхбаярын Батиугар гишүүн Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойрог ирсэн байна, Хассуурийн Ганхуяг 26 дугаар тойрог ирсэн байна, Бадарчийн Жаргалмаа 27 дугаар тойрог ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг 24 дүгээр тойрог ирсэн байна, Чинбатын Ундрам Сэлэнгэ 13 дугаар тойрог ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн 23 дугаар тойрог ирсэн байна, Содномын Чинзориг 10 дугаар тойрог ирсэн байна, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан 17 дугаар тойрог ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Ингээд ирц бүрдсэн тул хурлаа эхэлье.

Хэлэлцэх асуудал.

Нэгдүгээрт, Шинжлэх ухаан технологийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдэх тухай асуудал,

Хоёр, Соёлын Бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдэх тухай асуудал.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэг бэлдэх тухай асуудлыг хэлэлцье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанд оролцох ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ганболдын Ганбаяр Боловсрол шинжлэх ухааны дэд сайд, Ханджавын Батжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Доржготовын Баттогтох Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Дүгэрийн Рэгдэл ШУА-ийн ерөнхийлөгч, Цэен-Ойдовын Намчинсүрэн, Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжлэх ухаан технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Төмөрпүрэвийн Намнан ШУТИС-ийн ректор. Содномдаржаагийн Мөнхбат Шинжлэх ухаан технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Доржгочоогийн Одгэрэл ШУТС-ийн захирал, Чимэдийн Ганзориг МУИС-ийн Нано технологийн төвийн захирал.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн

ажлын хэсгийн ахлагч Баагийн Баттөмөр танилцуулна.

Ажлын хэсгийн ахлагчийн микрофоныг нээж өгнө үү. Баттөмөр гишүүний.

Б.Баттөмөр: Байнгын хорооны гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн. Бид ажлын хэсэг хуралдаад зарчмын зөрүүтэй саналын томъёололыг боловсруулсан байгаа.

Энэ мөн нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын даргаас төслийн нэр томъёоны тодорхойлолтыг найруулгаар засах үүрэг өгсөн нь ингээд засагдсан.

Ингээд Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулан оруулж байгаа зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Мөнхцэцэг: Дэгийн тухай хуулийн 42.1.3-д заасны дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах тухай чиглэл өгсөн нэг зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураалгах санал.

1.Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.10-д заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Ингээд санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Өчигдөр чуулганаар бас нэр бүхий гишүүн энэ тал дээр л яриад байсан л даа. Тэгэхээр бид энэ дээр их тайлбар их ойлгомжтой өгөх ёстой. Би бол дэмжээд байгаа. Би өөрөө дэмжиж байна. Ялангуяа энэ шинжлэх ухааны бүтээлүүдийг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэдгээр энэ туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд гэж байгаа.

Тэгэхээр энэ эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх гэдэг маань

ер нь бол бид төр Засгийн газар захиалгаа аль болох л төрийн шинжлэх ухааны байгууллагуудаар хийлгэж хөрөнгө оруулалт хийж байгаа л нэг хэлбэр шүү дээ. Би тэгж хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр санааг ер нь их сайн тайлбарлаж өгч ойлгуулахгүй бол энэ дээр одоо ингээд тоглолт хийгээд хэн дуртай нь зүгээр л ялчих юм байна, авчих юм байна гээд байгаа юм. Энэ чинь бараа зарах гээгүй байхгүй юу. Энэ утга нь өөр. Хөрөнгө оруулалт хийж, ажил гүйцэтгүүлэх энэ эрдэм шинжилгээний бүтээлүүдийг амь оруулахад л чухал гэж хараад байгаа юм.

Тийм учраас энийгээ яг аргуудтаа их зөв хэлж өгч тайлбарлах нь их чухал юм байна лээ шүү. Тэгээд би энийг дэмжиж байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

Ц.Мөнхцэцэг: Асуулт биш санал хэллээ гэж ойлгоё. Өөр асуулттай гишүүн.

Ундрэм гишүүн асуулт асууна.

Ч.Ундрэм: Энэ заалтыг ер нь дэмжиж байгаа юм аа.

Тэгээд манай Засгийн газар, төрийн өмчит төрийн оролцоотой байгууллагууд бүгдээрээ янз бүрийн судалгаа техник, эдийн засгийн үндэслэл гээд маш их хэмжээний нийлбэр дүнг нь харах юм бол их хэмжээний мөнгийг зарцуулдаг. Тэгээд тэрийг нь янз бүрийн болсон болоогүй компаниуд авчихдаг учраас яг өөрийнхөө төрийн оролцоотой эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаагаа гүйцэтгүүлэх нь зөв. Гэхдээ энэ дээр нэг их сургуулиудыг нэмчхэж болохгүй юу? Төрийн оролцоотой их сургуулиуд заавал дотроо ир эрдэм шинжилгээний нэгжтэй биш мундаг профессорын багууд байгаа шүү дээ. Их сургууль дээр. Өөрийн гэсэн лабораторитой болчихсон тийм байгууллагууд байгаа.

Тэгэхээр энэ дээр их сургуулийг оруулж өгөх ёстой байх аа. Тэнд байгаа тэр олон мянган эрдэмтдийн хүний нөөцийг бид нар бас ашиглах тэр бололцоог нь нээж өгөх ёстой байх аа. Тэгээд нэмчихвэл. Боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага гэж тодорхойлогддог шүү дээ. Их сургууль чинь. Яг орох уу тэ? Хууль дээрээ орчихсон болж байна. Тэгвэл протоколд ямар ч л байсан их сургууль орж байгаа гэж албан ёсоор тусгууль аа.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Ундрэм гишүүний хууль санаачлагч Энх-Амгалан сайд хариулна.

Л.Энх-Амгалан: Ундрэм гишүүн бол маш чухал, Чинбүрэн гишүүн 2 бол чухал саналыг хөндөж байгаа юм аа. Энэ тэгээд үндсэндээ бол манай одоо энэ шинжлэх ухааны статистик гаргахад шинжлэх ухааны бүх юунууд дээр нэр томъёо хуулиуд дээр эрдэм шинжилгээний байгууллага гэдэг их дээд сургуулиуд гэдэг юу ордог энэ хамааралд энэ хүрээндээ ингэж ордог. Тэгээд энэ дээр ч гэсэн давхар санаа бол нөгөө их сургуулийн харьяа төрийн өмчит хүрээлэнгүүд байгаа шүү дээ тийм ээ. Тэгэхээр ингээд энэ төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага гэдэг дотор их сургуулиуд болон их сургуулийн харьяа хүрээлэнгүүд орж байгаа гэдгийг бас би албан ёсоор хэлье.

Баярлалаа. Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн 28 дугаар тойргийн Анужин гишүүн ирсэн байна. Мөн 28 дугаар тойргоос сонгогдсон Ням-Осорын Учрал гишүүн тус тус ирсэн байна.

Ингээд гүйцээн боловсруулах чиглэл өгсөн нэг саналаар санал хураалт явуулья.

Санал хураалт.

Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 90.9 хувь нь дэмжсэн

байна. Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн төсөл шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулга унших гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Ажлын хэсгийн ахлагч Баагаагийн Баттөмөрийг томилъё.

Ингээд дараагийн асуудалдаа оръё.

9.18 цагт

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэг бэлтгэх тухай асуудлыг хэлэлцье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсгийн гишүүдийг оруулна уу.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэх Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Чинбатын Номин Соёлын Сайд, Пүрэвсүрэнгийн Баттөр Соёлын дэд сайд, Готовцэрэнгийн Батхуяг Соёлын яамны соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга, Содномжамцын Батцэцэг Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Цэрэндоржийн Чулуунбат Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн, Дашийн Өлзий-Орших ая зохиогч продюсер, дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн тэргүүн, Доржсүрэнгийн Болд Б продакшны захирал, Дашнямын Батмагнай М мюзик ХК-ийн захирал, Ганжуурын Төгсбаяр Өмгөөллийн Төгс энд Кр ХХК-ийн захирал, Энхсайханы

Тамир Монголын Анимэйшний холбооны гүйцэтгэх захирал.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Чинбатын Ундррам танилцуулна.

Ч.Ундрам: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Соёлын, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэж шийдвэрлэж, анхны хэлэлцүүлгийг 2024 оны 5 сарын 3-ны Улсын Их Хурлын чуулганаар хийсэн байгаа.

Хуулийн төслийн ажлын хэсэгт миний бие ахалж Улсын Их Хурлын гишүүн Адьяасүрэн, Анужин, Аубакир, Батишугар, Дамдинням, Жаргалмаа, Г.Мөнхцэцэг нар орж ажилласан. Улсын Их Хурлын зүгээс 2 асуудал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсэг ажиллаад та бүхэнд зарчмын зөрүүтэй саналын 2 томъёололыг бэлдэж тараасан байгаа.

Тэгээд та бүхнийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёололтой танилцаж хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Дэгийн тухай хуулийн 42.1.3-д заасны дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Анужин гишүүнээр эхэлье. Анужин гишүүний микрофоныг нээж өгнө үү.

П.Анужин: Баярлалаа санал байхгүй. Би энэ нөгөө гүйцээн боловсруулах чиглэл авсан 2 юуг л авах гэсэн юм, энэ авчихлаа. Баярлалаа дарга.

Ц.Мөнхцэцэг: Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 2 саналаар санал хураалт явуулъя.

Ингээд та бүхэнд саналын томъёоллийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу бэлтгэсэн санал.

1.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, /цаашид тохиолдол бүрт нийцүүлэн өөрчлөх/, 12.4 дэх хэсгийн “нөхцөл,” гэсний дараа “системийн мэдээллийг бүрдүүлэх этгээдэд тавих шалгуур,” гэж нэмж, 12.9 дэх хэсгийн “төрөөс” гэснийг болон 12.10 дахь хэсгийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай “12.8” дахь хэсэг нэмэх:

“12.8.Энэ хуулийн 12.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн 17.2-т заасан объектын төрөл тус бүрийн зохиогчийн эрх эзэмшигчийн олонхийг нэгтгэсэн байна.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалтыг цуцалъя.

Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг тодруулга авна.

Х.Ганхуяг: 12.4 болохоор юуны тухай л журам байна л даа Засгийн газар батлах юм байна. Энэ нөгөө нөхцөл дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална гээд ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр системийн

мэдээллийг бүрдүүлэх этгээдэд тавих шалгуурын журмыг Засгийн газар батална гээд ороод ирсэн байна л даа. Нэгдүгээрт энэ системийн мэдээллийг бүрдүүлэх этгээд гэдэг маань яг аль хэсгийг нь хэлж байгаа билээ?

Хоёр дугаарт, тэгээд энэ яг Засгийн газрын эрхлэх асуудал руу орох уу, үгүй юу? Энэ нь зүгээр бараг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дээрээ энэ эрхийг нь өгвөл арай илүү оновчтой байх уу, үгүй юу л гэдэг л асуудлыг асуух гээд байгаа юм л даа.

Г.Мөнхцэцэг: Ганхуяг гишүүний асуултад хууль санаачлагч, Соёлын сайд Номин хариулна. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг нээж өгнө үү?

Ч.Номин: Баярлалаа. Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Энэ системийн мэдээллийг бүрдүүлэх этгээд гэдэг нь болохоор юу талаасаа явж байгаа. Хамтын удирдлагын байгууллага талаасаа явж байгаа. Одоо яг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд бол илүү хяналтыг нь тавьж явна. Хамтын удирдлагын байгууллага бол яг энэ хяналтын системээ өөрөө зохион байгуулж авч явах ажлыг хийнэ.

Ц.Мөнхцэцэг: Асуулт байна. Ажлын хэсгийн ахлагч Ундрэм гишүүн нэмж хариулна.

Ч.Ундрэм: Энэ хуулиар зохицуулж байгаа нэг чухал зүйл нь юу вэ гэхээр энэ оюуны өмч бүхий энэ соёл урлагийн бүтээлүүдийг тодорхой ийм тоолуурын системээр бүртгэдэг болох гэж байгаа юм. Эвент холлууд, караоке ч юм уу тэ ийм үйлчилгээний газруудад жишээлэх юм бол дуу хөгжим явах юм бол тэрийг нь ингээд бүртгээд авах гэх мэтчилэн. Тэгэхээр энийг тодорхой этгээдүүд тодорхой субъект энэ эрхийг эзэмшээд үүнийхээ дагуу үйл ажиллагаа явуулна. Соёлын яамнаас хяналт тавиад явах юм.

Тэгэхээр энэ субъектийг шалгаруулах шалгуурыг Соёлын яам журмыг нь боловсруулаад Засгийн газраар батлуулаад тэгээд тэрнийхээ дагуу явъя л гэсэн ийм санаа явж байгаа.

Х.Ганхуяг: Ганхуяг гишүүн тодруулга байхгүй юу болсон уу тэ? Ингээд гүйцээн боловсрох чиглэл өгсөн.

Санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтыг гишүүдийн 90.9 хувь нь дэмжсэн байна.

Дараагийн санал.

Хоёр дахь саналын томъёололыг та бүхэнд танилцуулъя.

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.3-12.6” гэснийг “12.3, 12.5, 12.7” гэж, “12.9 дэх хэсгийн “бүтээгдэхүүний зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн чиглэлээр” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага нь” гэж өөрчилж, 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.6, 12.7 дахь хэсэг болгох:

“12.6.Энэ хуулийн 12.3-т заасан систем хөгжүүлэлтийг гүйцэтгэх этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулна.

12.7.Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах системийн мэдээллийг бүрдүүлэх, хэрэглэх чиг үүргийг хамтын удирдлагын байгууллага, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан үндсэн чиглэл тус бүрийн мэргэжлийн нэгдсэн холбоо гүйцэтгэж болно. Холбогдох этгээдийг энэ хуулийн 12.4-т заасан шалгуурын дагуу сонгох, санхүүжүүлэх, хяналт тавих чиг үүргийг соёлын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ асуудлаар асуулттай гишүүн байна уу? Байхгүй бол санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтыг хуралдаанд оролцсон гишүүдийн 81.8 хувь нь дэмжсэн байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулга унших гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг томилъё. Өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудал өндөрлөснийг мэдэгдье.

Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА